



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 12

Номгон

**Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, “в”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 1.3, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор-Тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын хөрөнгөд бүртгэлтэй 7 нэрийн 533 747 418,68 төгрөгийн өртөг бүхий хавсралтад заагдсан хөрөнгийг Сум дундын Ойн ангид үнэ төлбөргүй шилжүүлсүгэй.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан ажлыг зохион байгуулахыг даалгасугай.

2.1 Тухайн байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг комисс томилон, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын хэрэгжилтийг 2019 оны 02 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлэх.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

D:/2018/Alban bichig/th togtool-2019

0119231



Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр сарын
31-ний өдрийн 12 дугаар тогтоолын хавсралт

БАЯНХОНГОР-ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ААС
СУМ ДУНДЫН ОЙН АНГИД ШИЛЖҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Аймаг /сум/- ын нэр	Байгууллагын нэр	Эд хөрөнгийн нэр	Ашиглал танд орсон огноо	Ой	НБҮ	Бүгд үнэ	Үлдэгдэл өртөг	Тайлбар
1	Баянхонгор	Баянхонгор-Төхжилт үйлчилгээ ОНӨААТҮГ	Ойн зурвасын мод	16.12.31	1	40000000	40000000,00	40000000,00	Улаанбаатар хотын Байгалиа дээдлье ХХК 2014 онд 70,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн боловч ихэнх мод нь ургаагүй 2016 онд 40,0 сая төгрөгөөр дахин мод суулгасан.
2	Баянхонгор	Баянхонгор-Төхжилт үйлчилгээ ОНӨААТҮГ	Хиймэл нуур	16.01.01	1	2083000000	2083000000,00	2083000000,00	Ус хуримтлуулах нуур буюу усан сан
3	Баянхонгор	Баянхонгор-Төхжилт үйлчилгээ ОНӨААТҮГ	Ганц толгой худаг	18.02.21	1	17902086	17902086,00	17902086,00	Мод үржүүлгийн хашаанд гаргасан худаг
4	Баянхонгор	Баянхонгор-Төхжилт үйлчилгээ ОНӨААТҮГ	Ойн зурвас хамгаалалт	18.09.19	1	47287699,7	47287699,68	47287699,68	ОНХС-ийн хөрөнгөөр Баяншар булаг ХХК ойн зурвасын шонг солисон, усан сангийн гаднах хашааг өндөрлөсөн
5	Баянхонгор	Баянхонгор-Төхжилт үйлчилгээ ОНӨААТҮГ	Усжуулалтын систем	18.02.21	1	219082633	219082633,00	219082633,00	Ойн зурвасын усжуулалтын систем ил шугамтай, дуслын системээр усалгаа хийх зориулалттай, хар хуван хоолойн шугам

6	Баянхонгор	Баянхонгор-Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	Кабель	18.12.31	1	675000	675000,00		675000,00	Арван мянгатын арын хаус хорооллын цахилгааны дэд өртөөгөөс буулгасан усны хамгаалалттай, насос руу орсон 380вт-ын 105м кабель
7	Баянхонгор	Баянхонгор-Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	Дэмжих насос	18.12.31	1	500000	500000,00		500000,00	1м гүнд ухаж байрлуулсан насос, гадна талаар нь блочнон хамгаалалт хийсэн.
							533747418,68	0,00	533747418,68	

оОо